



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Тариалан сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/83/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

Мөрөн хот

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: [baterdenee@audit.gov.mn](mailto:baterdenee@audit.gov.mn)

Аудитор: С.Гансүх

Утас: 95908400 Цахим хаяг: [gansuhs@audit.gov.mn](mailto:gansuhs@audit.gov.mn)

Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Т.Батсайхан

Утас: 99010760 Цахим хаяг: [tcc.audit.mn@gmail.com](mailto:tcc.audit.mn@gmail.com)

Аудитын менежер: Г.Оюунгэрэл

Утас: 77551229 Цахим хаяг: [tcc.audit.mn@gmail.com](mailto:tcc.audit.mn@gmail.com)

Ахлах аудитор: Д.Алтайбаяр

Утас: 77551229 Цахим хаяг: [tcc.audit.mn@gmail.com](mailto:tcc.audit.mn@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Залруулсан алдаа .....	16
4.2 Төлбөрийн акт .....	16
4.3 Албан шаардлага .....	16
4.4 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
АИТХТ	Аймгийн иргэдийг төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/192  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
Д.ДУЛАМСҮРЭН ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

	/төгрөг/	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>58,996,390.16</b>	<b>240,113,253.54</b>
<b>АВЛАГА</b>	<b>350,000.00</b>	<b>168,836,579.62</b>
Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	456,679.62
Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	168,379,900.00
Татаас, санхүүжилтийн авлага	350,000.00	00.00
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>58,646,390.16</b>	<b>71,276,673.92</b>
<b>Түүхий эд материал</b>	<b>21,043,572.16</b>	<b>23,654,732.92</b>
Эм боох материал	21,043,572.16	23,654,732.92
<b>Хангамжийн материал</b>	<b>36,812,291.00</b>	<b>46,831,414.00</b>
Бичиг хэргийн материал	1,035,810.00	1,321,610.00
Аж ахуйн материал	14,934,808.00	18,253,468.00
Түлш, шатах тослох материал	408,600.00	4,500,000.00
Хүнсний материал	657,323.00	4,180,086.00
Бусад хангамжийн материал	19,775,750.00	18,576,250.00
Мал амьтад	790,527.00	790,527.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>598,365,432.43</b>	<b>676,686,412.59</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>598,365,432.43</b>	<b>676,686,412.59</b>
<b>Биет хөрөнгө</b>	<b>560,453,232.43</b>	<b>653,049,212.59</b>
Барилга, байгууламж, орон сууц	537,126,260.45	529,750,778.81
Хуримтлагдсан элэгдэл	-59,559,576.74	-84,594,740.48
Авто-тээврийн хэрэгсэл	51,709,692.00	62,429,692.00
Хуримтлагдсан элэгдэл	-20,791,397.44	-26,657,489.20
Машин тоног төхөөрөмж (компьютер)	111,709,416.93	183,156,041.00
Хуримтлагдсан элэгдэл	-79,827,278.18	-40,307,951.78
Тавилга, аж ахуйн эд хогшил	47,060,909.00	47,164,437.00
Хуримтлагдсан элэгдэл	-26,974,793.59	-17,891,554.76
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>37,912,200.00</b>	<b>23,637,200.00</b>
Програм хангамж	15,725,000.00	725,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-725,000.00	00.00
Бусад биет бус хөрөнгө	22,912,200.00	22,912,200.00
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>657,361,822.59</b>	<b>916,799,666.13</b>
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>657,361,822.59</b>	<b>916,799,666.13</b>
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>657,361,822.59</b>	<b>916,799,666.13</b>
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	332,460,354.00	332,460,354.00
Өмч: - төрийн	332,460,354.00	332,460,354.00
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-105,340,326.56</b>	<b>160,681,510.81</b>
Өмнөх үеийн үр дүн	-105,340,326.56	-98,756,332.73
Тайлант үеийн үр дүн	00.00	259,437,843.54
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	430,241,795.15	423,657,801.32
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>657,361,822.59</b>	<b>916,799,666.13</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

		/төгрөг/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>678,811,113.02</b>	<b>1,852,694,471.16</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>47,628,883.02</b>	<b>547,159,011.16</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>47,628,883.02</b>	<b>547,159,011.16</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	47,628,883.02	547,159,011.16
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	47,628,883.02	547,159,011.16
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>146,571,030.00</b>	<b>807,285,860.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	484,611,200.00	498,249,600.00

<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>42,928,900.00</b>	<b>719,692,700.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	357,900.00	4,534,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,571,000.00	52,088,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,415,000.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	658,655,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>42,001,600.00</b>	<b>44,108,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,001,600.00	44,108,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>61,640,530.00</b>	<b>43,484,560.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	61,640,530.00	43,484,560.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>696,167,520.34</b>	<b>1,589,568,886.80</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>678,421,830.34</b>	<b>1,548,618,886.80</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>678,421,830.34</b>	<b>1,548,618,886.80</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>392,623,719.32</b>	<b>570,672,565.00</b>
210101	Үндсэн цалин	250,166,619.32	335,651,665.00
210102	Нэмэгдэл	118,677,100.00	170,256,900.00
210104	Урамшуулал	23,780,000.00	61,074,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	3,690,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>52,980,500.00</b>	<b>73,546,800.38</b>
210201	Тэтгэврийн даатгал	37,282,700.00	50,974,400.38
210202	Тэтгэмжийн даатгал	3,924,500.00	5,643,125.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,139,600.00	4,514,440.00
210204	Ажилгүйдлийн даатгал	784,700.00	1,128,585.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,849,000.00	11,286,250.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>40,599,094.00</b>	<b>41,480,023.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,500,000.00	2,962,823.00
210302	Түлш, халаалт	36,099,094.00	36,517,200.00
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	2,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>42,563,260.30</b>	<b>72,600,452.17</b>
210401	Бичиг хэрэг	2,650,750.00	2,813,500.00
210402	Тээвэр, шатахуун	24,297,620.00	41,879,905.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	4,742,016.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,000,000.00	1,832,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	14,587,800.00
210408	Бараа материал акталсны зардал	8,114,890.30	6,744,631.17
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>80,006,336.79</b>	<b>687,033,458.23</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,586,619.14	627,910,327.23
210502	Хоол, хүнс	14,419,717.65	59,123,131.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,524,000.00</b>	<b>11,500,000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	4,524,000.00	10,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,289,000.00</b>	<b>540,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,289,000.00	540,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,553,170.00</b>	<b>17,327,668.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,488,170.00	15,958,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	150,000.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,000.00	68,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	53,000.00	71,568.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	350,000.00	636,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>56,282,749.93</b>	<b>73,917,920.02</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,797,800.00	2,234,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,484,949.93	71,683,920.02
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17,745,690.00</b>	<b>40,950,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>16,172,000.00</b>	<b>40,950,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	40,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,172,000.00	350,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,573,690.00</b>	<b>00.00</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-17,356,407.32</b>	<b>263,125,584.36</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>58,393.49</b>	<b>3,687,740.82</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	58,393.49	3,687,740.82
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-58,393.49</b>	<b>-3,687,740.82</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-17,414,800.81</b>	<b>259,437,843.54</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>C01</b>	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>332,460,354.00</b>	<b>-87,925,525.75</b>	<b>674,776,623.40</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
<b>C03</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>332,460,354.00</b>	<b>-87,925,525.75</b>	<b>674,776,623.40</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	-17,414,800.81	-17,414,800.81
<b>C08</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>332,460,354.00</b>	<b>-105,340,326.56</b>	<b>657,361,822.59</b>
<b>D01</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>332,460,354.00</b>	<b>-105,340,326.56</b>	<b>657,361,822.59</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	6,583,993.83	6,583,993.83
<b>D03</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>332,460,354.00</b>	<b>-98,756,332.73</b>	<b>663,945,816.42</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	-6,583,993.83
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	259,437,843.54	259,437,843.54
<b>D09</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>332,460,354.00</b>	<b>160,681,510.81</b>	<b>916,799,666.13</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>631,182,230.00</b>	<b>1,137,505,560.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>631,182,230.00</b>	<b>1,137,505,560.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	484,611,200.00	498,249,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>42,928,900.00</b>	<b>551,662,800.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	357,900.00	4,534,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,571,000.00	52,438,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,415,000.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	490,275,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>42,001,600.00</b>	<b>44,108,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,001,600.00	44,108,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>61,640,530.00</b>	<b>43,484,560.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	61,640,530.00	43,484,560.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>622,463,230.00</b>	<b>1,127,035,560.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>622,463,230.00</b>	<b>1,127,035,560.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>604,367,540.00</b>	<b>1,086,085,560.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>392,449,300.00</b>	<b>570,672,565.00</b>
210101	Үндсэн цалин	249,992,200.00	335,651,665.00
210102	Нэмэгдэл	118,677,100.00	170,256,900.00
210104	Урамшуулал	23,780,000.00	61,074,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	3,690,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>52,980,500.00</b>	<b>74,003,480.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	37,282,700.00	51,431,080.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,924,500.00	5,643,125.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,139,600.00	4,514,440.00
210204	Ажилгүйдлийн даатгал	784,700.00	1,128,585.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,849,000.00	11,286,250.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>40,608,600.00</b>	<b>45,571,423.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,500,000.00	2,962,823.00
210302	Түлш, халаалт	36,108,600.00	40,608,600.00
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	2,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>34,957,620.00</b>	<b>63,458,071.00</b>
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	2,934,300.00
210402	Тээвэр, шатахуун	24,297,620.00	41,879,905.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	4,742,016.00
210404	Ном, хэвлэл	00.00	165,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,000,000.00	1,832,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,660,000.00	11,904,250.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>62,207,550.00</b>	<b>300,778,353.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,808,000.00	236,340,459.00
210502	Хоол, хүнс	14,948,550.00	62,437,894.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,451,000.00	2,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,524,000.00</b>	<b>11,500,000.00</b>

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	4,524,000.00	10,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,289,000.00</b>	<b>540,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,289,000.00	540,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,553,170.00</b>	<b>17,327,668.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,488,170.00	15,958,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	150,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,000.00	68,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	53,000.00	71,568.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	350,000.00	636,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,797,800.00</b>	<b>2,234,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,797,800.00	2,234,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,095,690.00</b>	<b>40,950,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>16,172,000.00</b>	<b>40,950,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	40,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,172,000.00	350,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,923,690.00</b>	<b>00.00</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>8,719,000.00</b>	<b>10,470,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>8,719,000.00</b>	<b>10,470,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,719,000.00</b>	<b>10,470,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>8,719,000.00</b>	<b>10,470,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,719,000.00	10,470,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-8,719,000.00</b>	<b>-10,470,000.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	603,643,800.0	585,842,760.0	17,801,040.0	97.1
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	603,643,800.0	585,842,760.0	17,801,040.0	97.1
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	603,643,800.0	585,842,760.0	17,801,040.0	97.1
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	395,719,100.0	395,719,100.0	00.0	100.0
210101	Үндсэн цалин	249,992,200.0	249,992,200.0	00.0	100.0

Тариалан сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	118,256,900.0	118,256,900.0	00.0	100.0
210104	Урамшуулал	23,780,000.0	23,780,000.0	00.0	100.0
210105	Гэрээт ажлын хөлс	3,690,000.0	3,690,000.0	00.0	100.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	53,422,100.0	53,422,100.0	00.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	37,593,400.0	37,593,400.0	00.0	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,957,200.0	3,957,200.0	00.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,165,700.0	3,165,700.0	00.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	791,400.0	791,400.0	00.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,914,400.0	7,914,400.0	00.0	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	40,608,600.0	40,608,600.0	00.0	100.0
210301	Гэрэл, цахилгаан	2,500,000.0	2,500,000.0	00.0	100.0
210302	Түлш, халаалт	36,108,600.0	36,108,600.0	00.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.0	2,000,000.0	00.0	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	35,550,000.0	32,864,136.0	2,685,864.0	92.4
210401	Бичиг хэрэг	1,500,000.0	1,450,051.0	49,949.0	96.7
210402	Тээвэр, шатахуун	24,500,000.0	22,651,285.0	1,848,715.0	92.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,250,000.0	3,250,000.0	00.0	100.0
210404	Ном, хэвлэл	300,000.0	165,000.0	135,000.0	55.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.0	1,832,600.0	167,400.0	91.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,000,000.0	3,515,200.0	484,800.0	87.9
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	55,443,000.0	45,024,156.0	10,418,844.0	81.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	36,023,000.0	31,490,136.0	4,532,864.0	87.4
210502	Хоол, хүнс	17,420,000.0	11,534,020.0	5,885,980.0	66.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.0	2,000,000.0	00.0	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	15,097,700.0	14,970,000.0	127,700.0	99.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,597,700.0	10,470,000.0	127,700.0	98.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.0	1,000,000.0	00.0	100.0
210604	Урсгал засвар	3,500,000.0	3,500,000.0	00.0	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,760,000.0	00.0	1,760,000.0	00.0
210702	Дотоод албан томилолт	1,760,000.0	00.0	1,760,000.0	00.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,043,300.0	1,677,668.0	365,632.0	82.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	308,100.0	308,100.0	00.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.0	400,000.0	00.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.0	150,000.0	00.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,000.0	68,000.0	00.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.0	44,000.0	00.0	100.0
210807	Газрын төлбөр	73,200.0	71,568.0	1,632.0	97.8
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.0	636,000.0	364,000.0	63.6

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,000,000.0	1,557,000.0	2,443,000.0	38.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.0	1,557,000.0	2,443,000.0	38.9
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	603,643,800.0	585,842,760.0	17,801,040.0	97.1
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	498,249,600.0	498,249,600.0	00.0	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	498,249,600.0	498,249,600.0	00.0	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	44,108,600.0	44,108,600.0	00.0	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	44,108,600.0	44,108,600.0	00.0	100.0
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	61,285,600.0	43,484,560.0	17,801,040.0	71.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	61,285,600.0	43,484,560.0	17,801,040.0	71.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	29.00	29.00	00.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00	00.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00	00.0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>551,662,800.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>551,662,800.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>510,712,800.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>174,953,465.00</b>
210101	Үндсэн цалин	85,659,465.00
210102	Нэмэгдэл	52,000,000.00
210104	Урамшуулал	37,294,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>20,581,380.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	13,837,680.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,685,925.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,348,740.00
210204	Ажилгүйдлийн даатгал	337,185.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,371,850.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>4,962,823.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	462,823.00
210302	Түлш, халаалт	4,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>30,593,935.00</b>
210401	Бичиг хэрэг	1,484,249.00
210402	Тээвэр, шатахуун	19,228,620.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,492,016.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,389,050.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>255,754,197.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	204,850,323.00
210502	Хоол, хүнс	50,903,874.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,000,000.00</b>
210604	Урсгал засвар	7,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>540,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	540,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,650,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,650,000.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	677,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	677,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	40,950,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	40,950,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	40,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	350,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	551,662,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	551,662,800.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,534,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,438,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,415,000.00
131106	Төсвийн урамшуулал	490,275,100.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тариалан сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудалд өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Ахлах аудитор Д.Алтайбаяр, аудитор О.Оюунцэцэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Гансүх, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар, Төгс суурь стандарт аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл, гүйцэтгэх захирал Т.Батсайхан нар хэрэгжүүлж, аудитын тайланг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулна.

Тариалан сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Тариалан сумын эрүүл мэндийн төв нь 2021 онд Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанар аюулгүй байдлыг хангасан, ил тод хүртээмжтэй үзүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгуурлан, ард иргэдэд эрүүл зөв амьдрах дадал үйлийг оновчтой тэгш хүртээмжтэйгээр хүргэж, орон нутгийн иргэдийн дундаж наслалт, амьдралын чадамжийг уртасгах, халдварын эрсдэлийг багасган, хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулж ажиллах зорилго тавьсан байна.

Хөвсгөл аймгийн Тариалан сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай

иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах

- Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх
- Сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх
- Сум, тосгоны эрүүл мэндийн төв түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны 04 сарын 30-ны 67/A/268 дугаар тушаалаар Ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналтын баг нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө гарган, улиралд нэг удаа хяналт хийж, тайланг удирдлагын багт танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тариалан сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн нийт зардал 603.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80-хувиар буюу 7.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тариалан сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 259.4 сая төгрөгөөр буюу 39.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Дансны авлага	0.35	168.8	168.5
Бараа материал	58.6	71.3	12.6
Үндсэн хөрөнгө	598.4	676.7	78.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>657.4</b>	<b>916.8</b>	<b>259.4</b>
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	430.2	423.6	-6.6
Хуримтлагдсан үр дүн	-105.3	160.7	266.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>657.4</b>	<b>916.8</b>	<b>259.4</b>

Авлагын үлдэгдэл 168.5 сая төгрөгөөр өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас Ковид-19 цар тахлын үед иргэдэд үзүүлсэн цогц тусламж үйлчилгээний зардал 168.8 сая төгрөгийн санхүүжилтийн авлагын үлдэгдэлтэй холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 12.6 сая төгрөгөөр өсөж 71.3 сая төгрөг болсон. Дансны үлдэгдэлд материаллаг нөлөөтэй бараа материалын орлогыг харуулбал:

- 2021 онд улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан 377.1 сая төгрөгийн бараа материал,
- Аймгийн эрүүл мэндийн газраас эрх шилжүүлэн өгсөн вакцин, эм тариа, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл 374.7 сая төгрөг,
- Сумын засаг даргын 2021 оны 12 сарын 09-ний А/166 дугаар захирамжаар Сумын засаг даргын Тамгын газраас эрх шилжүүлэн өгсөн 18.6 сая төгрөгийн эм тариа, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл,
- ДЭМБ-ын МонПен төслийн хүрээнд ЭМГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/149 дугаар тушаалаар эрх шилжүүлэн олгосон 5.7 сая төгрөгийн оношлуур,
- Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/32 дугаар тушаалаар аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс хандиваар авсан 4.7 сая төгрөгийн бараа материал тус тус орлогод авсантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 78.3 сая төгрөгөөр өсөж 676.6 сая төгрөг болсон.

Материаллаг нөлөөтэй үндсэн хөрөнгийн орлогыг харуулбал:

- Улсын төсвийн хөрөнгөөр 10,4 сая төгрөгийн тоног төхөөрөмж,
- Аймгийн ОНӨГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 1/121 дугаар тушаалаар 13.1 сая төгрөгийн мотоцикл,
- Аймгийн ОНӨГ-ын даргын 2021 оны 9 дүгээр сарын 16-ны А/100 дугаар тушаалаар аймгийн ОНХС-с 30.0 сая төгрөгийн ЭХО аппарат,
- Аймгийн ОНӨГ-ын даргын 2021 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн А/96 дугаар тушаалаар 9.7 сая төгрөгийн хог хаягдлын автоклав,
- Аймгийн ОНӨГ-ын даргын 2021 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар Ашид буян ХХК-аас 16.7 сая төгрөгийн мобайл технологийн тоног төхөөрөмж,
- Аймгийн ОНӨГ-ын даргын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдррийн А/16 дугаар тушаалаар 12.0 сая төгрөгийн гематологийн аппарат,

- МонПен төслийн хүрээнд ЭМГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/149 дүгээр тушаалаар 1.2 сая төгрөгийн шээсний анализатор, 2.5 сая төгрөгийн компьютер,
- Аймгийн ОНӨГ-ын даргын 2021 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн А/98 дугаар тушаалаар 1.1 сая төгрөгийн зөөврийн хүчилтөрөгч аппарат, 17.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж,
- ХӨСҮТ-ээс 4.7 сая төгрөгийн вакцины хөргөгч,
- Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор 33.7 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж орлогод авсан.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 12 сарын 20-ын өдрийн 109 дүгээр тогтоолоор 24.3 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга хэрэгсэл, барилга байгууламж тус тус акталж данснаас хассан.

Аймгийн ИТХ -ын тэргүүлэгчдийн 2021 оны 12 сарын 20-ы өдрийн 111 дүгээр тогтоолоор 54.4 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлэхээр мөн данснаас хассан.

Хуримтлагдсан үр дүн 160.7 сая төгрөг болж 266.0 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд нөлөөлсөн гол хүчин зүйл нь тайлангийн жилийн ашиг байна.

Нийт зардал нь өнгөрсөн оноос 2 дахин өссөн. Материаллаг нөлөөтэй гол зардлуудыг харуулбал:

- Ковидтой холбоотойгоор эрүүл мэндийн даатгалын сангаас нэмэлт санхүүжилт авч, цалингийн зардал 178.2 сая төгрөгөөр,
- Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 21.1 сая төгрөгөөр,
- Хангамж бараа материалын зардал 28.5 сая төгрөгөөр,
- Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл 238.5 сая төгрөгөөр өссөн,
- Эд хогшил, урсгал засварын зардал 7.0 сая төгрөгөөр,
- Бусад урсгал шилжүүлэг 22.9 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг нийт зарлагыг 603.6 сая төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2021 онд улсын төсвөөс 498.2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 44.1 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 61.3 сая төгрөг нийт 603.6 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 4 зориулалт бүхий арга хэмжээг санхүүжүүлэхээр 585.8 сая төгрөгийн санхүүжилт авч 17.8 сая төгрөгөөр дутуу санхүүжсэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Материаллаг нөлөөтэй нэмэлт санхүүжилтийн орлогыг харуулбал:

- Төрийн болон орон нутгийн өмчийн бус хуулийн этгээд, хувь хүнээс 4.5 сая төгрөгийн бараа материал, мөнгөн хөрөнгө,
- Аймгийн ЭМГ-аас ажиллагчдад олгох урамшуулал 40.6 сая төгрөг, илүү цагийн хөлс 7.6 сая төгрөг, нэгдсэн эмнэлгээс сорьц тээвэрлэсний зардал 3.8 сая төгрөг, нийт 52.1 сая төгрөгийг дээд шатны төсвийн эрх захирагчаас эрх шилжүүлэн олгосон,
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4.4 сая төгрөг,
- Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого 490.3 сая төгрөг, нийт 551.3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал. Үүнд:

- Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан. Ковидын тархалттай холбогдсон Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ихээхэн нэмэгдсэн. Ковидоор 816 хүн өвчилж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан, дархлаажуулалтаар 8219 тун вакцинд иргэдийг хамруулж нийт 654.9 сая төгрөгийн зардал гаргаж нэхэмжилснээс 486.5 сая төгрөгийн санхүүжилт авч ЭМД-ын сангаас 168.4 сая төгрөгийн авлагатай гарсан. Авлагыг тулган баталгаажуулсан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аудитаар материаллаг буруу тайлагналын болон нөлөө бүхий эрсдэл гараагүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 хамаарах төсөвт байгууллага төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6-р зүйлийн 6.1-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зориулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Тариалан сумын эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 1,552.6 сая төгрөгийн 105 мэдээллийг хугацаанд нь ил тод, бүрэн мэдээлсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны А/387/99 журамд нэмэлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай
- “Хөвсгөл аймгийн засаг даргын захирамж” 2021 оны А243 түр журам батлах тухай. Ковид-19-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх түр журмаар баталсан байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өнгөрсөн онд Ихэр мөрөн аудит ХХК аудит хийж 2 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар нийт 4.5 сая төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрсэнд, 4.5 сая төгрөгийн 1 алдаа залруулж, 1 зөвлөмж өгөв.

### **4.1 Залруулсан алдаа**

Нийт 4.5 сая төгрөгийн байр ашиглалтын зардлыг бүлэг хооронд шилжүүлснийг аудитын хугацаанд залруулсан болно.

### **4.2 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### **4.3 Албан шаардлага**

Албан шаардлага хүргүүлээгүй болно.

### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

Хөвсгөл аймгийн Тариалан сумын эрүүл мэндийн төв нь хуучин нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлт” оруулах, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалын 8 дугаар зүйлийн 8.1-т Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийг баримтална” гэж заасантай нийцэхгүй байна.

##### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлт” оруулах, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалын 8 дугаар зүйлийн 8.1-т Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийг баримтална” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тариалан сумын эрүүл мэндийн төв	2	4.5	1	4.5	-	-	-	-	1	-